



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 1/47

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Буянт-Ухаа” болон “Чингис хаан” олон улсын нисэх буудлын хэрэглэлээр буулт үйлдэх систем, зай хэмжих төхөөрөмжийн ээлжит шалгалтын нислэгийг гүйцэтгэхэд агаарын хөлгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:

М.Байгал

(Иргэний нисэхийн үндэсний төвийн нислэгийн журам боловсруулалт, шалтгалтын нислэгийн албаны нислэгийн журам зохиох хэсгийн дарга)

Гишүүд:

Ж.Баттунгалаг

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Агаарын навигацийн үйлчилгээний газрын мэргэжилтэн)

М.Оргил

(“Сэтгэл зүй судалгаа, мэдээллийн төв” Төрийн бус байгууллагын гишүүн (тохиролцсоноор))

Б.Мэндсайхан

(“ХУД Яармаг” Төрийн бус байгууллагын гишүүн (тохиролцсоноор))

Нарийн бичгийн
дарга:

Ч.Ганзориг

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө

оруулалт, захиалагчийн албаны Худалдан авах
ажиллагааны тасгийн мэргэжилтэн)

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (М.Байгал)-нд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал), Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендерт оролцоход үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанад хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ч.Ганзориг)-д даалгасугай.

ДАРГА



Ч.МОНХТУЯА